



# Зурагзүйн дүрслэлийн аргууд

10р анги. 1.2 хичээл

# Газарзүйн зургийн ангилал:

## 1. Ерөнхий

- Хотгор гүдгэр, гол мөрөн, нуур зам харилцаа, хот суурин зэрэг нь тойм байдлаар дүрслэгдэнэ.

## 2 Сэдэвчилсэн


- Геологийн тогтоц, хөрс, хүн ам, уур амьсгал, засаг захиргааны хуваарь, ургамлын бүрхэвч гэх мэт тусгайлан нэг зүйлийг харуулна.

## Сэдэвчилсэн зураг:

- ▶ Энэ зурагт дүрслэлийн янз бүрийн аргыг хэрэглэдэг.  
Жнь:
- ▶ 1. Тэмдгийн арга
- ▶ 2. Ареалын арга
- ▶ 3. Өнгөт дэвсгэрийн арга
- ▶ 4. Ижил шугамын арга
- ▶ 5. Хөдөлгөөнт шугамын арга
- ▶ 6. Цэгийн арга
- ▶ 7. Картодиаграммын арга
- ▶ 8. Анаморфын арга

# 1. Тэмдгийн арга

Юмс үзэгдлийн орон зайн байршлыг геометрийн хэлбэр, дүрс, үсэг зэргээр тэмдэглэнэ. Тэмдэг нь юмсын байрлалаас гадна хэмжээ, шинж чанар ба төрлийг илэрхийлнэ.



## 2. Ареалын арга

Нэлэнхүй ба заримдаг тархсан юмс үзэгдлийн тархалт, байршлын хил хязгаарыг өнгө, зураас болон шугам, тодорхой юмсыг төлөөлсөн дүрсийг ашиглан үзүүлнэ.




### 3. Өнгөт дэвсгэрийн арга

Нутаг дэвсгэрийн хүрээнд нэлэнхүй тархсан үзэгдлийн шинж чанарын ялгааг өнгөөр илэрхийлэх арга. Ихэвчлэн улс төрийн ба засаг захиргааны зурагт хэрэглэнэ.



## 4. Ижил шугамын арга


Тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үзэгдлийн тасралтгүй үргэлжлэн, өөрчлөгдсөн шинж байдлыг дүрслэхэд хэрэглэдэг. Ижил шугам нь аливаа үзэгдлийн ижил тоон утгатай цэгүүдийг холбосон муруй юм.





## 5. Хөдөлгөөнт шугамын арга

Байгаль, нийгмийн үзэгдлийн орон зайн шилжих хөдөлгөөнийг сум зураас зэргийг ашиглан үзүүлэх арга. Тэдгээрийн өнгө нь шинж чанарыг, өргөн нь тоо хэмжээг илэрхийлнэ.





## 6. Цэгийн арга


Тодорхой тоон үзүүлэлтийг төлөөлсөн цэгийн тусламжтайгаар үзэгдлийн тоо хэмжээ, байршил, төрөл зэргийг үзүүлэх арга. Хүн амын ба хөдөө аж ахуйн зурагт уг аргыг өргөн хэрэглэнэ.

ХҮН АМЫН ТАРХАЛТ , БҮС НУТАГ, АЙМГААР, 1 ЦЭГ 1000  
ХҮНЭЭР, 2000 ОНЫ ТООЛЛОГООР




## 7. Картодиаграммын арга

Үзэгдэл юмсын цаг хугацааны өөрчлөлт, тоо хэмжээ, дотоод бүтцийн ялгаа зэргийг нутаг дэвсгэрийн хүрээнд, диаграммаар илэрхийлэх арга юм. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, эрчим хүчний хэрэглээ зэргийг уг аргаар үзүүлнэ. Диаграммын төрлүүд нь тойргон, баганан, квадрат гэх мэт олон янз байна.



## 8. Анаморффын арга

Аливаа байгаль, нийгмийн үзэгдэл юмсыг компьютер графикийн тусламжтай тархалт, байршил, хэмжээ, хүчийг харуулсан картодиаграмм, картограммын шинэ арга юм.





# Дасгал 1. Дараах 2 зурагнаас юуг харж бна вэ? Тодрхойлж бичнэ үү? Мөн ямар аргаар зурсан бна вэ?





Figure 7. Global Power Plant Fleet by Technology



Source: Power plant data source Platts UDI Database, June 2012  
Note: Circle size represents installed capacity (MW).

## Дасагл 2. Аймгуудын хүн амын тоог зурагзүйн дүрслэлийн арга болох цэгэн аргаар дасгалын зурагт тэмдэглэнэ үү?

Аймаг, нийслэл	Хүн амын тоо				Жилийн дундаж өсөлтийн хувь		
	2010	2020	2030	2040	2010-2020	2020-2030	2030-2040
Архангай	83 827	77 630	71 975	68 895	-0.7	-0.7	-0.4
Баян-Өлгий	84 423	86 974	91 849	102 619	0.3	0.6	1.2
Баянхонгор	75 394	71 665	66 502	62 327	-0.5	-0.7	-0.6
Булган	53 240	48 358	42 339	36 281	-0.9	-1.2	-1.4
Говь-Алтай	53 144	47 171	40 955	35 934	-1.1	-1.3	-1.2
Дорноговь	57 243	66 570	75 371	86 787	1.6	1.3	1.5
Дорнод	68 841	67 245	62 863	58 076	-0.2	-0.7	-0.8
Дундговь	38 651	33 959	29 513	25 863	-1.2	-1.3	-1.2
Завхан	65 238	51 451	39 597	31 144	-2.1	-2.3	-2.1
Өвөрхангай	100 009	95 622	91 399	90 779	-0.4	-0.4	-0.1
Өмнөговь	59 969	77 258	96 440	116 464	2.9	2.5	2.1
Сүхбаатар	50 864	48 731	46 452	45 706	-0.4	-0.5	-0.2
Сэлэнгэ	95 219	95 741	95 197	97 884	0.1	-0.1	0.3
Төв	83 745	75 613	66 393	58 643	-1.0	-1.2	-1.2
Увс	75 797	71 992	70 321	72 460	-0.5	-0.2	0.3
Ховд	72 668	68 778	66 105	67 246	-0.5	-0.4	0.2
Хөвсгөл	113 636	114 218	112 327	111 947	0.1	-0.2	0.0
Хэнтий	65 027	62 842	60 509	60 630	-0.3	-0.4	0.0
Дархан-Уул	90 075	99 058	104 426	108 219	1.0	0.5	0.4
Улаанбаатар	1 147 095	1 668 797	2 103 158	2 441 683	4.5	2.6	1.6
Орхон	86 250	107 109	127 874	150 700	2.4	1.9	1.8
Говьсүмбэр	12 957	14 303	15 314	16 708	1.0	0.7	0.9
<b>Улсын дүн</b>	<b>2 633 312</b>	<b>3 151 086</b>	<b>3 576 877</b>	<b>3 946 997</b>	<b>2.0</b>	<b>1.4</b>	<b>1.0</b>